

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын ТТЗ-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/022/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг:
erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг:
tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88012671 Цахим хаяг:
ichinkhorlooga@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунтуяа

Утас: 99036832 Цахим хаяг:
ariuntuyab@audit.gov.mn



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ШИНЭ-ИДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ц.ГАНБААТАР ТАНАА

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 1/331
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Шинэ-Идэр сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд хандиваар болон ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт болох 349.5 сая төгрөг, ИТХ-ын үндсэн хөрөнгө 0.8 сая төгрөг, Шинэ-Идэр дулаан Эрдэнэт ХХК-ын үндсэн хөрөнгө 168.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 8 иргэнтэй холбоотой 32.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Шинэ-Идэр сумын Засаг дарга нь нь аймгийн Засаг даргатай 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 94.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

6725022210

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		313,240.8	574,601.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	131,813.9	316,138.4
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	98,597.1	176,293.3
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	82,829.8	82,169.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,279,275.6	2,418,670.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	2,157,275.6	2,418,670.0
39200	Биет хөрөнгө		2,114,701.8	2,374,718.3
39300	Биет бус хөрөнгө	13	42,573.8	43,951.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		2,592,516.4	2,993,271.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		7,817.7	62,914.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	7,817.7	62,427.1
41300	Өглөг	17а, 17б	7,817.7	62,427.1
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		0.0	487.0
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	0.0	487.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,584,698.7	2,930,357.1
51	Засгийн газрын хувь оролцоо		2,584,698.7	2,930,357.1
51100	Засгийн газрын оруулсан капитал		953,041.1	953,041.1
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		687,676.4	838,676.4
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		24,539.5	24,539.5
51200	Хуримтлагдсан үр дүн		394,803.8	630,977.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		524,637.9	483,122.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		2,592,516.4	2,993,271.2

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,543,263.0	1,678,464.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	342,199.6	626,619.9
110	Орлогын албан татвар	241,282.6	549,560.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	266,681.1	549,560.7
113	Хөрөнгийн албан татвар	51,584.1	48,045.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	49,332.9	29,013.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	60,683.2	-264,967.3
120	Нийтлэг татварын бус орлого	60,683.2	-279,967.3
121	Хөрөнгийн орлого	0.0	15,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,140,380.1	1,316,812.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,526,886.5	1,476,941.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,526,886.5	1,476,941.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,511,378.8	1,430,107.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	472,790.5	739,484.7

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,630.7	91,569.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,868.6	97,399.6
2104	Хангамж, бараа материалын зардал	93,110.7	62,472.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000.0	44,610.5
2107	Томилолт, зочны зардал	4,306.0	4,560.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	642,781.2	113,825.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	226,891.2	276,184.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,507.7	46,834.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	16,376.5	201,523.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.0	8,000.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	16,376.5	193,523.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,021,071.5	2,069,787.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	342,199.6	626,619.9
110	Орлогын албан татвар	241,282.6	549,560.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	266,681.1	549,560.7
113	Хөрөнгийн албан татвар	51,584.1	48,045.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	49,332.9	29,013.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,374.4	4,254.8
1181	Газрын төлбөр	2,806.0	5,312.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	40,152.6	19,446.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	538,491.7	126,355.8
120	Нийтлэг татварын бус орлого	538,491.7	111,355.8
121	Хөрөнгийн орлого	0.0	15,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,140,380.1	1,316,812.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,940,681.6	1,866,152.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,940,681.6	1,866,152.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,672,661.5	1,617,454.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	651,935.3	925,453.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,476.8	145,227.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	106,578.8	123,204.1
2104	Хангамж, бараа материалын зардал	158,410.6	196,122.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000.0	36,746.5
2107	Томилолт, зочны зардал	4,306.0	4,560.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	603,649.1	83,274.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,305.0	102,865.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	268,020.1	248,698.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	80,389.9	203,635.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	32,083.0	19,310.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	32,083.0	19,310.8
2200	Дотоод эх үүсвэрээр	32,083.0	19,310.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-32,083.0	-19,310.8
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-73,693.1	184,324.5

101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	205,507.0	131,813.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	131,813.9	316,138.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	2,568,322.2	2,568,322.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,568,322.2	2,568,322.2
9	Тайлант үеийн үр дүн	16,376.5	16,376.5
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,584,698.7	2,584,698.7
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,584,698.7	2,584,698.7
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	42,650.4	42,650.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,627,349.1	2,627,349.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-41,515.4	-41,515.4
17	Өмчид гарсан өөрчилөлт	151,000.0	151,000.0
19	Тайлант үеийн үр дүн	193,523.5	193,523.5
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,930,357.1	2,930,357.1

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сан, 1 ОНӨААТҮГ-ийн нийт 5 санхүүгийн тайланг нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 3 зөрчил илэрч, алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 3 зөвлөмжийг хүргүүллээ.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 18.4 сая төгрөгийн 2 алдаа, 8.8 сая төгрөгийн 5 зөрчил илэрсэн. Аудитын явцад 18.4 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 4.9 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах давтан гаргахгүй байхаар 2.9 сая төгрөгийн 3 зөвлөмж өгсөн байна.

5.1 Төлбөрийн акт

ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан төсвийн гүйцэтгэлийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

5.2 Албан шаардлага

Шинэ-Идэр сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар албан шаардлага өгөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарах асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй холбоотой асуудлын талаар

Аудитын илрүүлэлт:Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 8 иргэнтэй холбоотой 32.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 361 дүгээр тушаалаар баталсан "хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион

байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай болон Эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах.

2. Дотоод хяналттай холбоотой асуудлын талаар

Дотоод аудитын албаны гүйцэтгэсэн ажлын тайлангаас үзэхэд зөвлөл төлөвлөсөн ажлын хүрээнд хяналтуудаа бүрэн хийгээгүй буюу 5 ажилд хяналт хэрэгжүүлсэн, байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн 2.3. "Дотоод хяналт шалгалтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино." гэж заасантай болон Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтыг төлөвлөсөн арга хэмжээнүүдэд бүрэн гүйцэтгэж , үр дүнг тооцон ажиллах.

3. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд тайлант онд нийт 145 мэдээлэл оруулахаас 131 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 11 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлж, мэдээлэх хугацаа болоогүй 3 мэдээлэл байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг цахим системд хугацаанд нь бүрэн оруулж ажиллах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5."Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хугацаа хэтэрсэн зээлийн авлага	1	-					1	-
Дотоод хяналт	1	-					1	-
Дүн	2	-					2	-
Харьяа байгууллагуудын зөрчил								
Шинэ-Идэр сумын ЗДТГ	3	8,133.1	1	2,570.0			2	5,563.1
Тээвэр шатахууны зардлаас бэлэн мөнгөөр зарцуулалт хийсэн	1	1,908.9	1	1,908.9				
Байгаль орчин хамгаалах нөхөн	1	4,000.0	1	4,000.0				

Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын ТТЗ-ийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

сэргээх зардлаас Анхан шатны баримт хууль журамд нийцэхгүй зарцуулалт хийсэн								
Балансын урамшуулал	1	2,923.0					1	2,923.0
ОНХС-ийн хөрөнгө оруулалт	1	-					1	-
Ахмадын сангийн үйл ажиллагааг хууль, журамд нийцүүлэн явуулах	1	-					1	-
Дүн	4	8,831.9	2	5,908.9			2	2,923.3

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн данс	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Харьяа байгууллагуудын зөрчил								
Байгууллагын газрын үнэлгээ, бичиг баримттай холбоотой	1	-					1	-
Дүн	1						1	